

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг
Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-24
<hr/>	
1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./	5-23
2.“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	23-24

**Төрийн байгуулалтын байнгын хорооны
08 дугаар сарын 29-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Алтангэрэл, Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Л.Гантөмөр, Л.Мөнхбаатар, Э.Одбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Н.Учрал, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар үг хэлэв.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулан хэлэлцэх горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хэлэлцэхээр тогтов.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол

Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Эдийн засгийн бодлогын асуудал хариуцсан зөвлөх Б.Даваадалай, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын менежер, ахлах аудитор Д.Энхдалай, Б.Лхагвацэнд, С.Бат-Эрдэнэ, И.Эрдэнэцэцэг, Б.Болд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Бямбасүрэн, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Дотоод аудитын албаны дарга Ц.Батбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга В.Жавзан, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Санхүүгийн бодлогын хэлтсийн дарга Л.Сонор, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга Б.Ганзориг, Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга В.Рэнцэнханд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт, шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Б.Батдэлгэр нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга нар танилцуулав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх дүгнэлт болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, Ө.Шижир, Ц.Сандаг-Очир, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга Б.Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Ө.Шижир, Ж.Баярмаа, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дотоод аудитын албаны дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Б.Батдэлгэр нар байлцав.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 16 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 24 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ингээд Байнгын хороонд хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Жудгийн Баярмаа гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн, Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн, Батын Батбаатар гишүүн ирсэн, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн, Бадрахын Найдалаа гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн, Баярмагнайн Баярбаатар ирсэн, Тогмид Доржханд гишүүн ирсэн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн, Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна.

Ингээд ирц бүрдсэн тул 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хоёр асуудал байгаа.

Нэг асуудал. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Нэг асуудал. Нөгөөдхийг нь горимоор оруулах асуудал байна тийм үү?

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Нэг асуудал байгаа. Би асуудлыг бас та бүхэнд танилцуулъя. Нөгөө хуулийнх нь төсөл байна уу?

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5.4 дээр Төрийн байгуулалтын байнгын хороодын дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх нам, эвслийн бүлэг, Байнгын хороо, дэд хороо, хууль санаачлагчийн саналыг нэгтгэн зөвлөлд танилцуулах бөгөөд зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар тогтоолын төслийг батална гэж байгаа.

Тэгэхээр Байнгын хорооноос, Төрийн байгуулалтын байнгын хорооноос чуулганы тухайн чуулганы хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганд оруулдаг ийм хуультай байгаа. Ер нь хуулиараа тухайн чуулганы, өмнөх чуулган дуусахаас 10 хоногийн дотор бол тухайн чуулганаар дараагийн чуулганд хэлэлцэх асуудлыг батлах ёстой байдаг. Бидний хувьд сонгуультай жил учир энэ асуудлыг бас баталж чадаагүй.

Тийм болохоор Байнгын хорооноос тогтоол гаргаж, энэ намрын чуулганаар хэлэлцэх асуудлыг батлах учиртай юм. Ингээд “Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудал оруулъя гэсэн саналтай байна. Энэ саналыг оруулж ирж байна. Үүнтэй холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу?

Батын Батбаатар гишүүн байна.

Б.Батбаатар: Их Хурлын даргын зөвлөлөөр энийг хэлэлцээд орж ирдэг

санагдаад байх юм. Үгүй бил үү наашаа оруулж ирэхдээ? Эндээс хэлэлцээд даргын зөвлөл рүү оруулах юм байна тээ? За за.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгвэл хоёр дахь асуудлыг хэлэлцэх асуудалд оруулах санал санал хураалт явуулъя. Эхлээд туршилтын санал хураалт явуулаадахъя. Санал хураалт.

13 гишүүнээс 9 гишүүн, 69 хувийн саналаар туршилтын санал болж байна. Санал хураалт явуулъя.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд тогтоолын төслийг хэлэлцэхээр болж байна. Хэлэлцэх асуудал руугаа орё.

Нэгдүгээр асуудал.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхлүүлъя.

Ажлын хэсэг орж ирж байна уу? Ажлын хэсгийг танилцуулъя. Бямбажавын Ганбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Даньхүүгийн Баянбилэг Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Лхагвын Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Пүрэвээгийн Дэлгэрнаран Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Цэвээнжавын Батбаатар Улсын Их Хурлын Тамгын газрын Дотоод аудитын албаны дарга, Батсуурийн Даваадалай Ерөнхийлөгчийн Тамгын газрын Эдийн засгийн бодлогын асуудал хариуцсан зөвлөх, Баатарын Лхагвасүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга, Жигжидсүрэнгийн Бямбасүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Вандансүрэнгийн Жавзан Төрийн албаны

зөвлөлийн ажлын албаны дарга, Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга, Бэлтрэгийн Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Наранхүүгийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ванчингийн Рэнцэнханд Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга, Д.Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Ц.Наранчимэг Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор гэсэн хүмүүс ажлын хэсгээс ирсэн байна.

Эхлээд хэн танилцуулга хийх билээ? Тулга сайд уу? Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Тулга сайд танилцуулна.

Б.Тулга: Та бүгдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 27-ны өдрийн

нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газар санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын Шадар сайд, Өрсөлдөөний асуудал хариуцсан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын нийт 172 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 903.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардал 525.8 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 377.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 24.6 хувь буюу 222.3 тэрбум төгрөгийг Ерөнхий сайд, 33.5 хувь буюу 30.4 тэрбум төгрөгийг Эдийн засгийн хөгжлийн сайд, 22.5 хувь буюу 202.8 тэрбум төгрөгийг Шадар сайд, 19.4 хувь буюу 175.6 тэрбум төгрөгийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын зарлага эзэлж байна.

Улсын төсвөөс 886.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 17 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд тус тус хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Загджав даргын микрофон 3 номер уу, 4, 6 номер уу? 6 номерын микрофон.

Д.Загджав: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 5 тайлан нэгтгэснээс 2 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гарган 3 байгууллагыг

аудит түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа байгууллагын санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 84.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 20.6 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 20.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

2.Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд нэгдсэн 3 байгууллагын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 698.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

3.Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуултын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд 6, санхүүгийн тайлан нэгтгэснээс, 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 2 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 3 байгууллагад өөрчлөлтгүй, 1 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7.3 тэрбум төгрөгийн 29 зөрчил илэрснээс 5.8 тэрбум төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 318.8 сая төгрөгийн 10 албан шаардлага хүргүүлж, 1.2 тэрбум төгрөгийн 17 зөвлөмж өгч,

хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл, тайлантай холбоотой нийт 5 тэрбум төгрөгийн 9 алдаа илэрснээс аудитын явцад 5 тэрбум төгрөгийн 8 алдааг залруулж, 68.6 сая төгрөгийн алдааг залруулсан зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 1.4 тэрбум төгрөгийн 12 зөрчил илрүүлснээс 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1.4 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 11 зөвлөмж өгсөн.

4.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 15 санхүүгийн тайлан нэгтгэснээс 5 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 10 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамрууллаа.

Төсвийн эрхлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 4 байгууллагад өөрчлөлтгүй, 1 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудит нийт 369.2 сая төгрөгийн 11 зөрчил илрүүлснээс 361.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага хүргүүлж, 8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэл тайлантай холбоотой 1.1 тэрбум төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 347 сая төгрөгийн 7 зөрчил илрүүлснээс 191.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 155.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 84.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 23.1

тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 31 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсөл, арга хэмжээний санхүүжилт 78 хувийн үзүүлэлттэй байна.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 21.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 14.3 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс 14.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 1 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.

6.Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн цалингийн зардалтай холбоотой зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар илэрсэн 3 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 16 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тайлан тоонд бүрэн санхүүжих 1 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж санхүүжилтийн гүйцэтгэл 65 хувьтай байна.

7.Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн тайлант хугацаанд өр төлбөр үүсгэсэн бараа, материалын дансанд үндсэн хөрөнгө

бүртгэсэн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлэх өөрийн орлогыг төсвийн төсөлд тусгаагүй зэрэг 19 сая төгрөгийн төсвийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 4.9 тэрбум төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулаа.

8.Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын төсвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудит нийт 321.2 тэрбум төгрөгийн 3 алдаа илэрснээс аудитын явцад 321.2 тэрбум төгрөгийн алдааг залруулж, алдааг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Тус Байнгын хороо Аудитын дүн, дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарал хандуулахыг зөвлөж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулах.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь байгаа зөрчлийг арилгах, төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр үүсгэсэн тооцоо нийлж, баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн, эзэн холбогчгүй болж найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулж дуусгах. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Компанийн тухай хуульд ноогдол ашиг хуваарилах, төлөх талаарх хуулийн зөрүүтэй заалтаас шалтгаалан зарим төрийн өмчит хуулийн этгээд ноогдол ашиг

төвлөрүүлэхгүй байгааг анхаарч, хуульд өөрчлөлт оруулах саналыг уламжлах.

Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын төсвөөс Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн нийтийн тээврийн автобус худалдан авах гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтийг тоймлон танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлантай холбоотойгоор асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Баярлалаа. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг үзлээ. Тэгээд хуримтлуулаад хараад байхаар бараг нийтдээ 500-гаад албан тушаалтанд хариуцлага тооцох тоо дүгнэлт гарсан байна. Дүнг нь ингээд нэгтгээд үзэх юм бол дүнг нь алдчихлаа. Бараг их наяд даваад явах юм шиг байна. Яг эдгээр албан тушаалтнуудад дүгнэлтэд заасны дагуу хариуцлага тооцсон уу? Хэдэд нь ямар хариуцлага тооцсон бэ? Энд хариулж өгнө үү?

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Аудитын газраас. 6 номер. Нэрээ хэлээд, өөрийгөө танилцуулна шүү.

Ц.Наранчимэг: Найдалаа гишүүний асуултад хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Өөрийгөө танилцуулаарай.

Ц.Наранчимэг: Үндэсний Аудитын газар Наранчимэг. Төрийн аудитын байгууллагаас тухайн жилийн санхүүгийн тайлангийн буюу гүйцэтгэлийн аудит хийгээд хууль тогтоомж зөрчсөн асуудалд хариуцлага тооцох албан шаардлагыг томилдог эрх бүхий албан тушаалтанд нь хүргүүлдэг. Одоогийн танилцуулж байгаа энэ 2023 оны төсвийн гүйцэтгэлээр хариуцлага тооцуулахаар албан шаардлага хүргүүлсний энэний биелэлтийг 9 дүгээр сарын 5-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр албан шаардлагадаа хуулийн хугацааг зааж өгдөг.

Яагаад гэвэл 9 сараас эхэлж бид нар завсрын буюу давтан аудитаа хийж, үүгээрээ өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтээ хянаж, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт нь тайланд тусгаж хүргүүлдэг учраас хяналт арай болоогүй байгаа.

Биелэлтийг гаргаад бид бас Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр Байнгын хороонд хүргүүлэх үүрэгтэй болсон. Шинэ Төсвийн тухай хууль буюу Төрийн аудитын тухай хуульд орсон өөрчлөлтөөр. Биелэлт гарахаар танд хүргүүлье.

Ж.Бат-Эрдэнэ: Найдалаа гишүүн тодруулъя, микрофон өгье.

Б.Найдалаа: Баярлалаа. Үүнээс гадна аудитаас дүгнэлт, зөвлөмж авчхаад одоо энэ төсвийн зарцуулагч нар байгаа байх. Хариуцлага тооцсон тохиолдол байгаа юу, бусад аудитаас бусад?

Ж.Бат-Эрдэнэ: Засгийн газрын Хэрэг эрхлэхээс хэн байна? Энэ сайд нар нь сая гуйсаар байгаад, гуйсаар байгаад л гараад явлаа. 3 номер. 3 номер дээр хэн байгаа юм? 3 номер, өөрийгөө танилцуулаарай.

Б.Ганбат: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ганбат гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан дээр хөндлөнгийн аудитын байгууллага Үндэсний аудитын газраас санхүүгийн хөндлөнгийн аудитаа хийгээд, ингээд энэ зөвлөмж өгсөн зөвлөмж, акт, шаардлага энэ бүх юун дээрээ бол хариуцлага тооц гэдэг ийм асуудал тавигдсан бол тухайн асуудлаар тухайн чиглэлийн төсвийн шууд захирагч нь бол хариуцлагаа тооцоод ингээд явах хуулийн зохицуулалт бол одоо үйлчилж байгаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дээр бол 23 оны жилийн эцэст манайх Хэрэг эрхлэх газрын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын бүх байгууллагууд дээр бол санхүүгийн үйл ажиллагаа дээр бол гайгүй гэдэг ийм дүгнэлттэй үнэлэгдсэн байгаа. Тийм учраас бид бол хариуцлага тооцсон ийм юу бол алга байна. Зөрчилгүй санал, дүгнэлт авсан учраас.

Ж.Бат-Эрдэнэ: Шижир гишүүн.

Ө.Шижир: Баярлалаа. Бид нар ингээд энэ хаврын чуулганаар хэлэлцэх ёстой байсан асуудлыг одоо ингээд нэгдүгээрт хэлэлцэж байгаа юм. Тэгэхээр юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр өмнөх Их Хурлын бүрэн эрхэд байсан Их Хурлын гишүүд бас яг энэ Төсвийн тухай хуулийг ноцтойгоор зөрчсөн шүү гэж нэгдүгээрт хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт энэ яаралтай горим гээд яаралтайгаар бид нар маш олон асуудлуудыг одоо ингээд оруулж ирээд байна. Тэгэхээр энэ намрын чуулганаас эхлээд энэ асуудлаа бас Улсын Их Хурлын Тамгын газар анхаарахгүй бол бас болохгүй. Ер нь яаралтай горим гэдэг дээр улс оронд, улс орны тусгаар тогтнолд аюулгүй байдалд нөлөөлсөн эсвэл онц байдал зарласан, Монгол Улсын хил, түүний халдашгүй байдалд халдсан гэдэг ч юм уу, нэг бол дэлхий даяар

байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон иймэрхүү асуудлуудаар бид нар яаралтай асуудлаар хэлэлцэж байхгүй бол одоо ингээд төсвийн гүйцэтгэлийг өмнөх Их Хурлын хийгээгүй ажлыг бид нар ингээд хийчхээд байгаа юм. Тэгээд бас л ингээд л энэ Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулсан болоод л ингээд л асуудлуудыг шийдэж байна л даа.

Тийм болохоор хэд хэдэн асуулт байгаа юм. Энэ аудитын дүгнэлт дээр үнэндээ авах юм алга. Сая Найдалаа гишүүний юуг би тооцож үзсэн 2 их наяд болж байгаа юм. 500 гаруй албан тушаалтанд.

Тэгээд түүнтэй холбоотой ТӨК-уд нь бусад аж ахуйн нэгжүүдэд зээл өгдөг, бараг банк болон банк бус санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаа эрхэлдэг болсон байна. Түүнтэй холбоотой зөвхөн “Эрдэс Тавантолгой” компани дээр гэхэд 2.77 гэдэг чинь 2.8 их наяд төгрөгийн өр, авлага үүсчихсэн өнөөдөр энэ асуудлыг яаж шийдэх нь мэдэгдэхгүй, заримыг нь ингээд Нийслэл рүү шилжүүлж байх жишээтэй Засгийн газрын хүрээнд.

Тэгэхээр хэд хэдэн асуулт байгаа юм. Тэрний дараагийнх нь жишээ нь энэ гадаадын зээл, тусламжтай холбоотой 149 төсөл, хөтөлбөрийн санхүүжилт нь 85.7 хувь байгаа боловч ажлын гүйцэтгэл нь 48 хувь гэгчихсэн байгаа юм. Ажлынх нь гүйцэтгэл нь 48 мөртөө санхүүжилтийнхээ бараг 90 хувийг авчихсан байна гэдэг чинь одоо яг юу гэсэн үг вэ? Энийг ойлгохгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр энэ 149 ширхэг төсөл, хөтөлбөрийг олон нийтэд ил болгооч. Яг ийм ийм төсөл, хөтөлбөрүүд ээ гээд. Энэ гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа 1.2 их наядын энэ зээл, тусламж чинь эргээд хэсэг хугацааны дараа улсын төсөв дээр дарамт болж ирнэ шүү дээ. Энэ чинь зээл л юм чинь бид нар хэзээнээс төлөх ёстой болно. Тэгэхээр энэ буцаагаад энэ чинь дараа дараагийн улсын төсөв дээр

бас энэ дан ялангуяа энэ улсын төсөв боодог энэ байгууллага маш их хүндрэлтэй болно.

Дараагийнх нь төрийн энэ 22 тусгай сан байгаа. Энэ тусгай сан дээр Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх сангийн нөгөө асуудал чинь одоо хүртэл дуусаагүй. Одоо сангаас олгосон зээлийн 58 хувь буюу 99.4 тэрбум төгрөг буюу 100 тэрбум төгрөгийн зээл нь найдваргүй зээлийн буюу муу зээлийн ангилалд орно гэж юу гэсэн үг юм бэ? Энэ ямар учиртай зээл болоод нийт гаргасан зээлийн чинь бараг 60 хувь нь муу зээл болдог юм? Яаж олгосон юм? Энийг бас ил болгомоор байгаа юм. Би энийг шууд улс төрийн сонгууль угтсан зээл гэж харж байгаа. Тэгээд эдгээр асуултад хариулт авмаар байна. Дараа нь тодруулгаа авчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Байж байх уу? Хэн хариулах вэ? 2 номерын микрофон.

Б.Ганзориг: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг. Шижир гишүүний асуултад хариулъя.

Би гадаад зээл, тусламжийн төслүүдтэй холбоотой асуултад хариулъя. 2023 онд хэрэгжсэн нийт тэгээд таны хэлснээр 149 төслийн 108 төсөл нь зээлийн төсөл, бусад нь тусламжийн төслүүд байгаа. Тэгээд яах вэ энэ аудитын тайланд орсон 48.8 хувь гэдэг бол нийт төслүүдийн ажлын гүйцэтгэлийн дундаж хувь байгаа. Тэгэхээр саяын тэр аудитын дүгнэлтэд орсон 85 хувийн гүйцэтгэл гэдэг бол тухайн жилийнх нь ажлын санхүүжилтийн гүйцэтгэл байгаа. Тэгэхээр нийт ажлын гүйцэтгэлийг бол яг тухайн жилийн батлагдсан төсвийнх нь гүйцэтгэлтэй харьцуулах бас боломжгүй байгаа.

Яагаад гэхээр бүх төслүүдийн ажлын гүйцэтгэлтэй уялдуулж Сангийн яам санхүүжилтийг санхүү хийдэг байгаа. Өөрөөр хэлбэл, яг тухайн төсөл

болгон дээр нь аваад үзвэл санхүүжилт нь бол дандаа бодит ажлынхаа гүйцэтгэлтэй уялдаад явж байгаа. Тэгэхээр тэр 1.2 их наядын зээлийн ашиглалт нь 23 онд зөвхөн 85 хувьтай гарсан. Тэр нь бол төсөл болгон дээр нь задлаад үзвэл яг ажлын гүйцэтгэл нь дандаа санхүүжилттэйгээ уялдаад явж байгаа гэсэн үг. Тэгээд Улсын Их Хурлаас баталсан Төсвийн тухай хуулийн ер нь бол бид нар өргөн барих хавсралтаар манай 149 төслийн нэр, жагсаалт аль байгууллагаас санхүүжилт авч байгаа гээд бүх байгаа. Ер нь бол 23 онд хэрэгжсэн 19 төсвийн ерөнхийлөн захирагч дээр 19 хөгжлийн түни байгууллагаас авч санхүүжүүлсэн санхүүжилтүүд байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Тусгай сангийн талаар асуусан асуултад хэн хариулах вэ? Сангийн яамнаас байна уу? 2 номерын микрофон.

Б.Цогбадрах: Шижир гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах.

Тусгай сангуудаас Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сангийн үлдэгдлийг хэлсэн гэж ойлголоо. Тэгээд Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сан бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газар дээрээ яг энэ авлагын үлдэгдлээс гадна зүгээр ер нь энэ авлагыг хэрхэн барагдуулах талаар ямар ажиллагаа зохион байгуулж байгааг бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц дахь Жижиг, дунд үйлдвэрийн газар дээр байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулах уу? Шижир гишүүн.

Ө.Шижир: Засгийн газрын 22 тусгай сан байгаагаас 20-д нь шалгалт хийгээд 20 тусгай сангийн шалгалтын хүрээнд 256.7 тэрбум төгрөгийн зөрчил үүссэн гээд байгаа байхгүй юу. Тэр дундаас би зүгээр онцолж асуусан нь Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сан

Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангийн 100 тэрбум төгрөг буюу 99.4 тэрбум буюу ойролцоогоор 100 орчим тэрбум төгрөг нийт зээлийн чинь 60 хувь нь чанаргүй зээл болчихоод байгаа юм. Та нар бод доо. Хэрвээ тэнд төрийн байгууллага биш банк бус эсвэл банк байсан бол аль хэдийн дампуурчихсан байхгүй юу. Бүүр аль хэдийн дампуурчихсан. Тэгээд нийт зээлийн чинь 60 хувь чанаргүй байна гэдэг чинь ингээд аудит дүгнэлт бичээд л ингээд л орхиод байх юм уу, аль эсвэл энэний дараа нь асуудал болгож ярих юм уу? Нэгдүгээрт энэ дээр би аягүй тодорхой хариул л даа, хаана байгааг нь би асуугаагүй шүү дээ.

Дараагийнх нь энэ ТӨК-удын өр төлбөр гэдэг асуудал дээр яг Аудитын газар, Сангийн яам ямар бодлого баримт, ямар бодлого барьж байгаа юм бэ? Мөн энэ олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хийсэн гэрээ гээд нийтдээ 5.5 их наяд төр тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдлийг ашиглаагүй мөртөө 11 тэрбум төгрөгийн хүүгийн ашиглалтын хүүгийн төлбөр төлсөн гээд байж байгаа. Энэ ямар учиртай юм бэ? Энийг ашиглахад ямар хүндрэлүүд үүссэн юм гэдэг дээр бас тодорхой хариулт өгөөч. Тэгээд ер нь бол энэ улсын төсвийн хөрөнгө энэ ТӨК болон орон нутгийн өмчит компаниудын хөрөнгө өөрөө яг ийм цоорхой карман шиг, цоорхой хувин шиг л байна л даа. Айлаар ярих юм бол өнөөдөр олсон орлогоо бүгдийг нь ингээд энд тэнд тараагаад орхичихдог, орон гэртээ болон үр хүүхдэдээ 1 ч төгрөгийн хөрөнгө оруулалт хийдэггүй, олсон орлого байгаад байдаг, ахуй амьдрал нь сайжирдаггүй яг л нэг ийм л айл болчихоод байгаа юм энэ чинь. Улсаар ярих юм бол энэ олон төсөв, хөрөнгө чинь бүгдээрээ яг ийм үр дүнгүй урсаж алга болоод байна л даа. Тэгээд энэ хөрөнгийн менежментээ зөв хийж байж бид нар дараа дараагийн хөрөнгө оруулалтын төслүүдийг ярихгүй бол ганц ашигтай ажиллаж байгаа компаниасаа 2.7 их наяд төгрөгийн зээл аваад хэрэгжүүлнэ гэж юу гэсэн үг юм бэ? Тэгэхээр энэ тусгай сангууд, энэ

гадаадын зээл, тусламжтай холбоотой тодорхой хариулт өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Аудитын газар хариулъя. 5 номерын микрофон. 7 номерын микрофон 7.

Ц.Наранчимэг: Шижир гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайланд хязгаарлалттай санал, дүгнэлтийг өгсөн. Хязгаарлалттай гэдэг санал, дүгнэлт маань эрсдэлтэй асуудлуудаар бид санхүүгийн тайланг хязгаарлаж байгаа. Энд 2023 онд Төсвийн тухай хуулиар эргэн төлөгдөх нөхцөлдөө 14.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй гэсэн асуудал байгаа. Тайлант оны эцэст шууд зээлийн 58 хувь буюу 99.4 тэрбум төгрөгийн 347 зээлдэгчээс авах муу зээлийн ангилал байгаа нь энэ мөнгө эргэн төлөгдөх эрсдэл байгаа тул энэ дээр хязгаарласан байгаа.

Мөн сангийн идэвхтэй зээлдэгчийн үлдэгдлийн төлбөрийг шалгаж, нягтлан бодох бүртгэл, хөтөлтөд алдаа гарсан эсэхийг судлах, залруулж бүртгэх, санхүүгийн тайланд тусгаж хянан баталгаажуулж хийх, дүгнэлт гаргах ажлын хэсгийн шалгалтын үр дүнгээр зээлийн тооцооллын программд хаагдсан боловч санхүүгийн программд үлдэгдэлтэй хаагдаагүй 134 зээлдэгчийн 732.8 сая төгрөгийн зөрүү үүссэн байна гэсэн ийм асуудлаар бол Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан дээр хязгаарлалттай санал, дүгнэлтийг өгсөн байгаа.

Гадаадын зээл, тусламжийн хүрээнд бид 156 гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрт аудит хийсэн. Үүнээс 8 төсөл, хөтөлбөрт хязгаарлалттай гэсэн санал, дүгнэлтийг өгсөн байгаа.

Сангийн яам бол зээлийн энэ гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг хэр сайн ашиглаж байна тэнд бол санхүүжилтээ гаргадаг ийм зохицуулалттай. Гэхдээ энэ дээр бас анхаарах асуудлууд байгаад байгааг аудит тайландаа зөвлөмж болгож өгсөн байгаа.

Барилга угсралтын ажил хийж дууссан, ашиглалтад оруулсан боловч тухайн ашиглаж байгаа байгууллагын данс бүртгэлд шилжүүлэхгүй байгаа. Мөн зарим барилга угсралтын ажил.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх дээр нь Сангийн яам хариулах уу нэмж? Сангийн яам хариулаад дараа нь 5 номерын микрофон. Сангийнх, сан хариулна шүү. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх сан байх аа? 2 номерын микрофон.

Б.Ганзориг: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг гишүүний асуултад хариулъя.

Сая ярьсан тэр яг манай аудитын байгууллагаас бас хэлж байгаа төслүүдийн ашиглалтыг Сангийн яамнаас 2019 оноос эхлээд бүх төсвийн ерөнхийлөн захирагч дээр байсан зээлийн ашиглалтыг Сангийн яаман дээр нэгтгэсэн.

Яагаад гэхээр өмнө нь төсвийн ерөнхийлөн захирагч дээрээ байсан зарим төслүүд нь сайн явахгүй бол тухайн тэр батлагдсан зээлийн ашиглалтын дүн гарахгүйгээр ингээд хэмнэгдээд үлддэг. Сайн явж байгаанууд нь бол ингээд санхүүжилтгүй үлддэг байсан. Тэрийг бид нар 19 оноос хойш зохицуулалт хийгээд Сангийн сайдын багц дээр бөөнд нь тавиад ингээд гаргадаг болсон.

Яг өнөөдрийн байдлаар 23 оны жилийн эцсээр бол нийтдээ бид нар 149 төсөл хэрэгжүүлэх үед ер нь ашиглагдаагүй үлдэгдэл 10.2 их наяд

байсан. Одоо яг хэлэлцээрийн шатад явж байгаа 13 их наядын ийм төсөл, хөтөлбөрүүд байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл, манай Засгийн газрын хэмжээнд гэрээтэй нийтдээ ингээд 23 их наяд төгрөгийн төсөл, хөтөлбөрүүдийг бид нар ирэх жилүүдэд ашиглахаар ингээд хүлээгдэж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ санхүүжилтийг ер бид нар улсын төсөв дээрээ заавал зарлага тал дээрээ суулгаад тэгээд санхүүжилт хийгээд явах ёстой байгаа хуулиараа. Тэгэхээр ер нь төсвийн зарлагын хязгаарын өөрчлөлтийг бас сая төсвийн тодотголоор оруулсан та бүхэн мэдэж байгаа байх. Тэгээд ирээдүйд цаашид энэ төслийн зээлийн ашиглалтыг үе шаттайгаар нэмэгдүүлж явж байж энэ төслүүдийн үр ашгийг цаг хугацаанд нь төслүүдийг дуусгадаг болох энэ чиглэлээр ингээд Сангийн яам ажиллаж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: 5 номерын микрофон.

Я.Эрдэнэсайхан: Шижир гишүүний асуултад хариулъя. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан 2009 онд анх хамгийн анх байгуулагдсан. 2020 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар буюу Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг байгуулагдсан. Ингээд 2009-24 оны хугацаанд нийтдээ 712 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг улсын төсөв Хөгжлийн банкны бонд, эргэн төлөлт зэрэг эх үүсвэрээс бүрдүүлээд 1.1 их наяд төгрөгийг зээл болгож өгсөн. Энэ хугацаандаа нийтдээ 8947 зээлдэгчид зээл өгсний 7552 буюу 85 хувь нь зээлээ бүрэн төлж дуусаад байгаа юм.

Өнөөдөр мэдээж энэ асуудал үүсэж байгаа. Ер нь Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг 20 онд байгуулагдахад 145 тэрбум төгрөгийн муу зээл шилжиж ирсэн. Энийг энэ хугацаанд бид нар агентлаг дээрээ Хууль, тусгай активын хэлтэс гэж байгуулаад жил бүр хууль шүүх, хяналтын байгууллага боломжит бүх арга хэрэгслээр ажиллаж байгаа.

Жишээ нь, 2019 онд 2.8 тэрбум төгрөгийг л энэ чанаргүй ангиллаас төлөвлөдөг байсныг 20 онд 7, 21 онд 8.5, 22 онд 13, 23 онд 18.2 гээд нийтдээ 53.4 тэрбум төгрөгийг энэ 4 жилийн хугацаанд барагдуулсан. Цаана нь мэдээж бас энэ 2009 оноос эхлүүлээд авчхаад төлөөгүй зээлүүд бол байгаа. Энэ дээр бид нар бас ажиллагаа хийгээд ажиллаж байгаа.

Яг өнөөдрийн байдлаар шүүхийн шатад гэхэд 27 зээлдэгчийн 19 тэрбум төгрөгийг шүүхэд хандаад явж байна. Шүүхийн процесс бол маш удаан байгаа. Зарим зээлдэгчтэй гэхэд 5, 6 жил яваад шүүх дээр асуудал нь шийдэгдэхгүй ийм асуудлууд байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр гэхэд 84 зээлдэгчийн 51 тэрбум төгрөгийн асуудал шүүхийнхэн шийдвэр гаргаад эргэн төлөгдөх шүүхийн процесс шүүхийн шийдвэрийн процесс үйл ажиллагаа дээр явагдаж байна.

Шийдвэр гүйцэтгэх хуудас бичүүлэх гэхэд 20 аж ахуйн нэгжийн 2 тэрбум төгрөгийн асуудал, эрэн сурвалжлах буюу эзэн холбогдогч нь олдохгүй байгаа 4 зээлдэгчийн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Нэмж хариулах юм уу? 5 номерын микрофон.

Я.Эрдэнэсайхан: Нас барсан гэхэд 6 зээлдэгчийн 0.5 тэрбум, дамнуурсан 1 зээлдэгчийн 0.6, прокурор дээр 1 зээлдэгчийн 7.4, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь зогсоод дуусгавар болоод төлбөр тооцоогоо хийж байгаа 12 зээлдэгчийн 1.1 гэх мэтчилэн. Ингээд энэ 228 зээлдэгчтэй 104.4 тэрбум төгрөг дээр процесс ажиллагаанууд явагдаж байгаа. Мөн сангаас шууд олгохоос гадна арилжааны банкаар дамжуулаад өнгөрсөн хугацаанд зээл олгосон. Энэний хамгийн том зээлдэгчийн асуудал бол “Капитал” банкин дээр байгаа. “Капитал” банк нь 19 онд дамнуурсан. Үүнээс хойш бид нар мөнгөн хэлбэрээр зээлээ барагдуулахаар хөөцөлдөөд эрх хүлээн авагчаас ямар ч

боломжгүй болсон учраас өнөөдөр мөнгөн бус хөрөнгө буюу үл хөдлөх хөрөнгө санал болгоод үүнийг нь шилжүүлж авах ийм процесс ажиллагаануудыг хийгээд явж байгаа.

Ер нь Жижиг, дунд үйлдвэрийн газар байгуулагдсанаас хойш энэ сангийн үйл ажиллагаа маш олон төрлөөр эерэг болж явж байгаа. Зээл олголт сүүлийн жилүүдэд ил тод, шударга болсон. Энэ хугацаанд олгогдсон зээл бол ямар нэгэн асуудал үүсээгүй. Өмнө олгогдоод таны хэлдгээр муу байсан зээлдэгчдийн зээлийг төлүүлэх олон ажиллагаанууд хийгдэж байгаа. Мөн хяналт мониторингийг тогтмол хийдэг болсон зэрэг ажлууд хийж үр дүн гарч явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Түрүүн тэр Шижир гишүүн асууж байна лээ. Яагаад энэ 6 сар, 7 сард төсвийн гүйцэтгэл орж ирээгүй юм өмнөх парламентаар? Уг нь бол тайлан балансууд 5, 6 сард гараад дуусчихсан байдаг. Тэгээд энэ удаа ингээд дараагийн шинэ парламент дээр ингээд ээлжит бус чуулганаар, ер нь цаашидаа энэ төсвийн гүйцэтгэлийг ээлжит бус чуулганаар хэлэлцдэг байдлыг болимоор байгаа юм. Төсвийн төлөвлөлтийг, төсвийг батлахад хэдэн сар билээ, бид нар ярилцдаг билээ. Өргөн бариад, хэлэлцээд. Тэгээд Монгол Улсын төсөв хэдэн их наядоор яригдаж байгаа юм. Тэгээд тоо болгоны цаана мөнгө, ажил, сахилга бат, хариуцлага байж байгаа шүү дээ. Тэгээд батлахдаа болохоор ингэж бөөн цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулж баталчхаад гүйцэтгэлийг нь болохоор ийм халтуурдсан маягтай энэ жилийн 2023 оны төсвийн гүйцэтгэл гээд үнэхээр халтуурдаж, хэлбэрдэж байна шүү дээ. Ингээд оруулаад өнгөрөөсөн маягтай. Энэ төсвийн гүйцэтгэлийн энэ тайланд олон нийтийн оролцоог яаж хангасан юм? Энэ тоо болгоны цаана үнэхээр нөгөө татвар төлөгчдийн чинь хөлсөө дуслуулан байж өгсөн татвараар, хураамжаар,

төлбөрөөр өгсөн ард иргэдийн хөлс, хүч, хөдөлмөр л байгаа шүү дээ. Энийг яаж энэ төсвийн бүх шатын төсвийн ерөнхийлөн захирагч нар яаж дураараа аашилж, авирлаж, зарцуулж байдаг юм, яаж хэтрүүлж байдаг юм, яаж ингээж зарцуулсан байдаг юм? Энийг л бид нар ярих ёстой юм байгаа юм шүү дээ.

Гэтэл энийг яг ярих үедээ ингээд ийм ээлжит бус чуулган, сонгуулийн дараа төр засаг солигдсон ийм эрээвэр хураавар, ороо бусгаа байгаа үед ингээж оруулж ирж ингээж тайлан тавьсан болж ингээж байгаа нь үнэхээр хариуцлагагүй байна. Тэгээд хэдхэн, 7 хоногийн дотор л ярих гэж байна шүү дээ яаралтайгаар оруулж ирж.

Яамдын сайд нарын чинь, төсвийн яамнууд, Төрийн нарийн чинь хэдэн их наядаар нь зурж байгаа биз дээ? Гарын үсэг зурж байгаа шүү дээ. Гадаад зээлийнх нь гүйцэтгэл ямар байгаа юм, хөрөнгө оруулалтынх нь гүйцэтгэл ямар байгаа юм, урсгал зардлынх нь ямар байгаа юм? Үгүй ингээд яривал маш их асуудлууд байгаа шүү дээ. Улсын Их Хурал өөрөө бас энэ Засгийн газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарын энэ гүйцэтгэлд тавих хяналтаа бас сул тавьж байна л гэж би ойлгож байна.

Харин ёстой энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарыг ёстой долоон булчирхайг нь тоочхож асууж байх ёстой шүү дээ санхүүгийн тайланг нь. Яагаад ингээд хэтрүүлсэн юм? Яагаад ингээд гүйцэтгэлд тайлан гараагүй юм? Яагаад ийм зөрчил гаргасан юм? Яагаад ийм эрүүгийн онц ноцтой шинжтэй ч хүртэл асуудал ярьж байна лээ шүү дээ. Тэгвэл учир шалтгааныг нь хаанаа байгаа юм? Тэгээд энэ улсуудад ямар арга хэмжээ авах юм? Ингээд жил жил төсвийн гүйцэтгэлийг ингээж халтуурдаж явдаг учраас жил жил.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүнд 1 минут нэмж өгье.

Ц.Сандаг-Очир: Төсвийн гүйцэтгэлд ач холбогдол өгөхгүй жил болгон ингээд тайлан хэлэлцсэн болоод өнгөрдөг учраас жил болгон санхүүгийн зөрчил дутагдал чинь буурахгүй байгаа юм, гарсаар байгаа юм. Тийм учраас хариуцлагын арга хэмжээгээ цаашидаа чангаруулахгүй бол ингээд л жил болгон зөрчил гарч л байдаг юм, аудитын тайлан гарч л байдаг юм, тайлангаа танилцуулж л байдаг юм ингээд л өнгөрдөг. Толгойг нь ингээж илсээр байгаад өнөөдөр энэ асуудал чинь хэвээр яваад байна. Санхүүгийн зөрчил дутагдал гарах ёстой юм уу эсвэл байх ёстой зүйл гэж ойлгоод байгаа юм уу? Таслан зогсоож болохгүй юм уу? Тийм учраас Аудитын тайлан, Аудитын дүгнэлтэд өөрөө Засгийн газар, өөрөө Их Хурал ач холбогдол өгөхгүй байна л даа. Арга хэмжээ авах хариуцлагын арга хэмжээ нь сул байна л даа.

Тийм учраас жил болгон зөрчил дутагдал гарсан хэвээр байгаа юм. Тийм учраас цаашидаа ээлжит бус чуулганаар энэ гүйцэтгэлийг хэлэлцдэг биш яаралтайгаар хэлэлцдэг биш нэлээн ач холбогдол өгч хэлэлцдэг баймаар байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ.

Би ганц, хоёр зүйл асуугаадахъя. Аудитын газраас асууя. Сая энэ гишүүдийн асуусан зүйлүүд бол ерөөсөө хяналттай холбоотой зүйлүүд яриад байна шүү дээ. Энэ Байнгын хорооноос гарах тогтоол, танилцуулга дотор энэ Сандаг-Очир гишүүн энэ гишүүдийн хэлсэн зүйлүүдийг бүүр тодорхой оруулах юм шүү. Энэ хэлж байгаа зүйлүүдийг.

Өчигдөр байх би энэ Аудитынхантай уулзаад та бүхэнд бас саналуудаа хэлж байсан. Яах гэж Аудитын байгууллага энэ хуульд, Төсвийн тухай хууль дотор бид нар оруулж байгаад ийм том шалгалтуудыг оруулаад, дүгнэлтүүдийг оруулж ирж байгаа юм бэ? Та бүхний танилцуулсан зүйлүүд дотор юу орж ирж байна гэхээр тэдэн зөрчил гаргалаа, сануулга өглөө,

тэдэн зөрчил илрүүлээ, хангалтгүй гэж хязгаарлалттай гэсэн дүгнэлт гаргалаа. Тэгээд ар дээр нь дахин зөрчил гаргахгүй байх зөвлөмж өглөө. Ийм л зүйлүүд гарч ирж байна шүү дээ.

Мэдээж Засгийн газар хэрэгжүүлсэн асуудал дээрээ бол тайлангаа тавина. Өөрсдөө бол аль болох алдаа, дутагдал багатай байх талаараа л мэдээж гаргаж таараа шүү дээ. Тэгэхээр энийг хаанаас, ямар байгууллага энийг бүрэн дүүрэн тайлан гаргаж ирж байна, зөв байна уу, буруу явж байна уу гэдэг асуудлуудыг чинь гаргаж ирэхийн тулд мэргэжлийн байгууллага Улсын Их Хурлын дэргэдэх ийм аудитын том байгууллага бид нар бол итгэл үзүүлээд аудит оруулж байгаа шүү дээ. Сая даргаас чинь асууя гэсэн дарга чинь гараад явчихлаа. Энэ Наранчимэг, Наранчимэг чинь юу хийдэг гэж байгаа билээ? Санхүү- Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, өөрөөр хэлбэл орлогч уу? Бараг, бараг тийм биз дээ? Тэр хэмжээнд явах байх.

Энэ та бүхний зөвлөмж өгсөн, хариуцлага тооц гэсэн зүйлүүдийг өгсөн байна. Тэнд бол хариуцлага тооцохыг нь болохоор сая Засгийн газар хэлэхдээ бол энэ Ерөнхий захирагч нарт нь өөрсдөд нь эрхийг нь өгчихдөг юм байна. Нөгөөдүүл нь хариуцлага тооцсон юм байдаггүй юм байна. Тэгэхээр хариуцлага тооцдог болохын тулд ямар хуульд ямар өөрчлөлт оруулах ийм боломж байх ёстой, ийм шаардлага байх ёстой юм гэдэг тал дээр надад хэлээдхээч. Тэрийг чинь засъя, хэдүүлээ хуульдаа оруулъя, хууль санаачилъя, тэр дотор оруулж байгаад хэдүүлээ дараагийн аудитаар ийм ийм ийм хариуцлага тооцоод, ингээд хариуцлага тооц гэсэн тооцоогүй байгаа учир ийм хуулийн дагуу, ийм хүнтэй, ийм улс төрийн албан хаагчтай, ийм сайдтай хариуцлага тооцмоор байна, Хэрэг эрхлэх газартай, тэр Ерөнхий сайдтай ингэж хариуцлага тооцмоор байна гэсэн зүйлүүдийг оруулах хэрэгтэй шүү дээ. Би өчигдөр, уржигдар та бүхэнд яг ийм

зүйлийг л хэлсэн. Тэгээд энэ микрофон дээрээ хариулт өгөөдхөөч. Ямар хариуцлагыг хуульд бид нар заах ёстой юм бэ? Энэ байхгүй болохоор бид нар ингэж зүгээр зөвлөмжөөр ингээд л жилийн жилд зөвлөмж өгөөд л яваад байна шүү дээ. Энэ дээр саналаа хэл дээ. Хариулт өгөөч.

Ц.Наранчимэг: хорооны даргын асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд хариуцлага тооцох асуудал тусгагдсан байгаа. Гэхдээ бид хариуцлага тооцох албан шаардлагыг томилдог эрх бүхий албан тушаалтанд нь хүргүүлдэг. Өмнөх Төрийн аудитын тухай хуульд сая шинэчлэн найруулга орохын өмнө хязгаарлалттай санал, дүгнэлт авбал хариуцлага тооцдог байсан. Саяын нэмэлт, өөрчлөлтөөр хязгаарлалттай санал, дүгнэлт авбал хариуцлага тооцдог асуудал бол хасагдаад, сөрөг санал, дүгнэлт авбал хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлнэ, татгалзсан санал, дүгнэлт авбал ажлаас халах албан шаардлагыг хүргүүлнэ гэсэн ийм хуулийн зохицуулалттай болсон.

Манай Төрийн аудитын тухай хууль бол хариуцлага тооцох тохиолдолд шууд Төрийн аудитын тухай хуулиар хариуцлага тооцох зохицуулалттай. Өмнөх бусад хуулиуд бол хамаагүй. Монгол Улсын Ерөнхий аудитор албан шаардлага өгөх юм бол хариуцлага тооцдог ийм асуудал байгаад байгаа юм.

Бидний өгч байгаа албан шаардлага, төлбөрийн акт бол заавал хэрэгжүүлэх, заавал биелүүлэх ийм албан шаардлага байдаг. Зөвлөмжийг бол бид зөвлөж байгаа алдааг зөрчилд бол албан шаардлага өгдөг, алдаанд бол зөвлөмж өгдөг. Алдааг яаж засаж залруулах вэ гэдэг арга замыг нь зааж өгдөг ийм олон улсын стандарттай. Энэ стандартынхаа дагуу энэ асуудлыг өгдөг байгаад байгаа юм.

7211 байгууллагад санхүүгийн тайлангийн аудитыг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд хийж гүйцэтгэж байгаа. Тэгэхээр байгууллага болгоны төсөв захирагч болгоны санхүүгийн тайлан дээр өөрсдөд нь байгаа алдаа, зөрчлүүдийг маш тодорхой бичээд өгчихсөн. Тухайн төсөв захирагч хэрвээ төсөв захирагчид хариуцлага тооцохоор бол дээд шатынх нь томилдог төсөв захирагчид албан шаардлага өгдөг. Та Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын хэлж байгаа бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас томилдог эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг өгөөгүй байна. Доор нь ажиллаж байгаа хүмүүст хариуцлага тооцох санал өгсөн учраас эдгээрийг томилдог эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцно гэсэн ийм хуулийн зохицуулалт байгаад байгаа юм.

Бид хуульд өөрчлөлт оруулах асуудлыг өчигдөр танаас Байнгын хороон даргын үүрэг аваад Монгол Улсын Ерөнхий аудитор газрын дарга нараа хуралдуулаад тодорхой өөрчлөлт оруулах саналуудыг судалж танилцуулахыг Тамгын газрын даргад бас үүрэг чиглэл өгсөн. Бид энэ дээр танд ямар зохицуулалт байвал үнэхээр сая Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуульд 2023 оны 7 дугаар сард орсон өөрчлөлтөөр бас нэлээд хариуцлагын тодорхой заалтууд нэмж орсон. Аудитаас өгсөн энэ тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагад төлөвлөгөө гаргаж ирүүлээгүй, 30 хоногийн дотор ирүүлээгүй бол хариуцлага тооцдог, биелүүлээгүй бол хариуцлага тооцох ийм нэлээн бас хариуцлагын заалтууд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ажлаас халах хүртэл арга хэмжээ авах заалттай хэдэн тэр сөрөг татгалзсан дүгнэлт гарсан юм? Тэрний арга хэмжээ авсан, аваагүй гэсэн тоо байна уу? 7 номер.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Энэ жилийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 262 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн байгаа. Үүнээс 32 албан тушаалтныг ажлаас чөлөөлөх албан шаардлага өгсөн. Түрүүн би хэлсэн 9 дүгээр сарын 5-наас бүх шатын энэ төсвийн байгууллагууд, ТӨК-д манайх завсрын аудит орно 24 оны. Үүгээр өмнөх өгсөн, энэ тайлангаар өгсөн тэр албан шаардлагын биелэлтээ хянадаг, яг газар дээр нь очиж давтан аудит хийж хянадаг байгаа. Үүгээр хянаж яг хэдийг чөлөөлсөн юм, ямар хариуцлага тооцсон юм, биелүүлсэн юм уу, биелүүлээгүй юм уу гэдэг ийм асуудал гарч ирнэ. Энэ жилийн тайланг нь бол. Өмнөх тайлангийн мэдээлэл байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хэрэг эрхлэх газрын дэд даргаас бас асууя. Саяын асуулт. Та бүхэнд ирсэн албан бичиг, тоот хэдэн хариуцлага, хэдэн зөрчил гаргасан төсвийн ерөнхийлөн захирагч нарт арга хэмжээ ав гэсэн ийм зүйлүүд ирсэн бэ? Тэрнээс арга хэмжээ авсан нь хэд байна вэ гэж? 3 номерын микрофон.

Б.Ганбат: Засгийн газрын Хэрэг эрлэх газрын Ганбат Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

23 оны санхүүгийн үйл ажиллагааны жилийн эцсийн энэ санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлтээр бол Засгийн газрын Хэрэг эрлэх газрын буюу Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн багцын харьяа байгууллага дээр бол зөрчилгүй гэдэг ийм санал, дүгнэлт авсан учраас бид хариуцлага тооцсон ийм тохиолдол бол энэ удаа байхгүй байна.

Одоо энэ төрийн аудиттай холбоотой, энэ санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой одоо яг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд бол Үндэсний аудитын газраас эрх бүхий аудиторуд

тавьсан төлбөрийн акт бол энэ хариуцлагын нэг хэлбэр болоод явж байгаа юм. Тэгэхээр энэ дээр тухайн байгууллага дээр санхүүгийн жилийн эцсийн үйл ажиллагаа дээр нь үзээд санхүүгийн томоохон хэмжээний ийм зөрчил, дутагдал байх юм бол тухайн аудитор бол актаа тавиад, төлбөрийн акт тавиад ингээд тэр төлбөрийн акт нь бол тухайн байгууллагын данснаас актад дурдсан тэр тоо хэмжээгээр суутгагдаад ингээд төлбөр нь Үндэсний аудитын газрын дансанд ордог ийм хэлбэр явж байгаа Энэ бол хариуцлагын бас нэг хэлбэр. Хамгийн хүнд маягийн хэлбэр нь энэ. Бусад сая Нараа даргын хэлж байгаа шаардлага, зөвлөмж бол өгч байгаа. Тэгээд Үндэсний аудитын газраас шаардлага, зөвлөмж авсан эрх бүхий төсөв ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нар бол өөрсдийн харьяалсан эрх бүхий харьяа байгууллагын албан тушаалтнуудад хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлагаа тооц.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Асуусан болоод явъя даа энэ чинь. Яасан шүү, өчигдөр яах юм байхгүй, миний тавьсан санал, миний тавьсан тэр үүрэг, даалгавар гэх юм уу, юу юм тэрийг аудитын газар хүлээж аваад байна гэж би ойлголоо. Тийм болохоор наадахтай холбоотой асуудлаараа хуульд ямар өөрчлөлт оруулах юм, буцаад эргэж хуулийн хяналт тавьдаг албан тушаалтанд арга хэмжээ аваагүй бол дээд албан тушаалтанд нь арга хэмжээ авах юм уу, эсвэл буцаж эргэж Улсын Их Хурал сонсдог байх. Энэ аудитын тайлангийн гүйцэтгэлийг магадгүй энэ аудитын тайлангийн дагуу хийсэн зарчмын асуудлууд дээр өөрчлөлт юу байдаг юм тэр бүх зүйл дээр нь буцаад Улсын Их Хурал хардаг, Байнгын хороогоор орж байдаг, хяналтад байдаг ч байдаг юм уу ийм тогтолцоог гаргахгүй бол болохгүй байна.

Тийм болохоор наадахтай холбоотой асуудлуудаа дахиад

боловсруулаад эргэж танилцуулъя гэдэг дээр тохирлоо шүү. Тийм.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна. Байна уу, дарсан уу? Баярбаатар дарга? Өшөө гараагүй байна. Шижир гишүүнийх Шижир гишүүн, Баярмаа гишүүн. Баярмаа гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Ер нь үндсэндээ төсвийн гүйцэтгэл ингээд хэлэлцэгдээд шувтрах гэж байх шиг байна. Өнөөдөр үдээс хойш Төсвийн зарлагын дэд хороо хуралдаад маргааш чуулганаар дуусах байх. Тэгээд энэ хөнгөн хуумгай хэлэлцэж баталсан сүүлийн гүйцэтгэл байгаасай л гэж би бодож байна. Тэгээд энэний дараа та бүхэн бас дотроо бодно биз. Ер нь энэний дараа яг юу үлдэв гэж? Ямар үр дүн үлдэв гэдгийг л. Бид нар энэ цаг заваа үрээд, та нар ч ажлаа алдаад ингээд сууж байгаагийнхаа энэ энэний дараа үр дүнтэй байх ёстой байхгүй юу. Тэгээд жилээс жилд ингээд хэлэлцсэн болоод л, асуултад нь хариулсан болоод л, тэгээд энд яг сууж байгаа энэ төрийн албан хаагчдын буруу ч гэж байхгүй л дээ. Төсвийн л ерөнхийлөн захирагчийнхаа өмнөөс л та нар сууж байгаа шүү дээ ер нь.

Тэгээд дараа дараагийн зүйлүүд дээр нэлээдгүй өндөр шаардлага тавина. Саяын Бат-Эрдэнэ даргын хэлдэг ажлыг хэрэгжүүлэх ёстой шүү. Одоо ингээд сая аудит ингээд л баахан зөрчил илрүүлээд л, баахан акт үйлдээд л байдаг, буцаад хариуцлага хүлээсэн юм байхгүй, нэг ч хүн ажлаас чөлөөлөөгүй гээд сууж байх юм. Өнөөдөр энэ төр гэдэг чинь зөвхөн дан парламент биш шүү дээ. Энэ төрийн нэр хүнд гэдэг чинь төрийн албаны байгууллага, төрийн албан хаагчийн ёс суртахуунаас эхэлж байгаа байхгүй юу. Би өчигдөр Байнгын хорооныхоо хурал

дээр хэлсэн шүү дээ. Энэ ёс суртахуун, ёс зүй гэдэг чинь зөвхөн хувь хүний хоорондын харилцаа биш шүү. Энэ төсвийн мөнгийг зөв зүйтэй зарцуулах нь өөрөө хүртэл ёс суртахууны асуудал юм шүү гэж.

Тэгэхээрээ дараа дараадаа нэлээн нэхэл хатуутай ажиллана. Дараа жилийн төсвийн гүйцэтгэл дээр энэ байдлаараа битгий орж ирээрэй гэж би бас та бүхэндээ хэлмээр байна. Тэр үед бас хэдүүлээ үр дүнтэй ажлаа дуусгаад аль болох энэ Сандаг-Очир гишүүний хэлж байгаа энэ алдаа дутагдлыг бууруулж, багасгаж орж ирээд, эргээд энэ төр түмнийхээ өмнө нүүр бардам асуултад хариулаад сууж байх шиг сайхан юм байхгүй л дээ. Дараа нь бид нар ч очоод сонгогчдодоо тайлан тавихад ийм байсныг ингэж янзалж, ийм зөрчлийг ингэж арилгаж төр ингэж ажиллаж байна гэдэг. Одоо ингээд энэ хэд хоногийн хэлэлцүүлгүүдийн дараа ингээд эргээд бодоход энэ гүйцэтгээд хэлэлцээд энд тэнд интернэт, фэйсбүүкээр л баахан бие бие рүүгээ загнасан, дайрсан бичлэгээс өөр л юм үлдсэнгүй л дээ. Яг ний нуугүй хэлэхэд. Бид нар гэж баахан ууртай байцаадаг хүмүүс, төрийн албан хаагчид нь загнуулж хариулсан улсууд. Тэгээд энэ зарчмаа хэдүүлээ үүгээр ингээд дуусгая. Дараа дараадаа бид нараас бас дэмжлэг, туслалцаа юу байдаг юм тэрийгээ аваад хамтраад, энэ зөрчлийг арилгахын тулд яах ёстой юм гэдэг дээр гарц, гаргалгаа гаргаад эрх зүйн орчныг нь боловсронгуй болгоод ингээд ажиллая гэсэн ийм санал байна. Би бол тэрнээс төрийн албан хаагчдыг, төрийн захиргааны албан хаагчдыг буруутгаад байгаа зүйл биш шүү. Ер нь зүгээр энэ өнгөрсөн хугацааны энэ ийм буруу жишигээ, буруу соёлыг бид нар зөв болгоё гэсэн л ийм зарчмын саналтай байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Шижир гишүүн.

Ө.Шижир: Уг нь Байнгын хороог илүү ажил хэрэгч бас бүтээлч байгаасай гэж дүгнээд Дэгийн тухай хуульд

өөрчлөлт оруулсан гэж би хувьдаа дүгнэсэн. Гэтэл одоо яг энд байгаа хүмүүсээс төсвийн ерөнхийлөн захирагч нэг ч алга л даа. Бат-Эрдэнэ дарга та хар даа нэг ч төсвийн ерөнхийлөн захирагч алга. Тэгэхээр ингээд Байнгын хороон дээрээ ийм асуулт асуусан болоод нөгөө хэд нь хариулсан болоод ингээд дуусдаг байвал бид нар Дэгийн тухай хууль эргээж харах зайлиггүй шаардлага үүснэ.

Яагаад гэвэл Байнгын хороо чинь ийм ажил хэрэгч байж чадахгүй байгаад байна шүү дээ. Тэгээд ер нь энгийнээр хэлэхэд та хэд ч гэсэн бүгдээрээ хувь хүн, бид нар ч бүгдээрээ хувь хүн. Улс орон чинь байтугай хувь хүн, гэр бүл, санхүүгийн сахилга баттай байж байж өнгө орж өөдөө дэвшдэг, хөгждөг, үр хүүхэд баяр баясалтай болдог шүү дээ. Тэгтэл одоо энэ ингээд өгсөн тайлан дээр чинь ингээд харахаар хэдэн 100 тэрбум, их наядаар хэмжигдэх хэмжээний зөрчлүүд яригдчихаад хэдүүлээ энд ингээд бие биеийнхээ асуултад хариулсан болоод ингээд суугаад байна л даа.

Тэгээд 2016 онд манай эрх барьж байгаа Монгол Ардын нам 1 хүнд хүнд ноогдох Монгол Улсын өр манцуйтай хүүхдээсээ авхуулаад бүх хүнд 15 сая төгрөгийн өр үүсчихсэн байна, бид нар өрөнд дарагдлаа гээд сонгууль хийгээд ялаад, хоёр сонгууль ялчихсан. Ингээд 3 дахь сонгуульдаа эрх барьж байгаа юм. Өнөөдөр энэ тоо 35 сая болсон.

Нийт тоогоороо, нийт дүнгээрээ улсын төсвийн хөрөнгө оруулалт зарлага, ТӨК-удын өр, зээл, хөрөнгө бүх юм нийт тоогоор өссөн мөртөө, нийт тоогоороо хамгийн багадаа 6 дахин өссөн байгаа шүү дээ. 6 дахин өссөн мөртөө иргэдийн амьдрал, худалдан авах чадвар 6 дахин сайжраагүй шүү. Тэрний гол шалтгаан юу вэ гэхээр та нарын энэ аудитын дүгнэлт байхгүй юу. Энэ аудитын дүгнэлтээр чинь хэрхэн төрийн мөнгө, ТӨК-удын мөнгө гарын салаагаар урсаж байгааг бид нар ингээд харж байгаа юм.

Монгол Ардын нам Монгол Улс олон төсөвтэй боллоо гэж байнга ярьсан. Би энийг маш сайн санадаг 2 төсөвтэй боллоо гээд. Одоо өнөөдөр хэдэн төсөв байгаа юм бэ? Улсын төсвөөс гадна Эрдэнэт, “Эрдэс Тавантолгой”, ТӨК-уд эд нар нь ингээд тусдаа төсөвтэй болоод нийгмийн халамжийн тус төлбөрүүдийг хэрэгжүүлдэг болчихсон. Тэгэхээр энэ аудитын дүгнэлт ингэж гарч таарна шүү дээ.

Тэгэхээр 2024 оны улсын төсөв дээр бодвол ирэх жилийн хаврын чуулганаар орж ирэх байх. Тэр үедээ бас энэ Бат-Эрдэнэ даргын хөндөөд байгаа зарим асуудлуудыг хууль, эрх зүйн хүрээнд хэрхэн өөрчилж болох вэ гэдэг саналаа оруулж ирээрэй. Оруулж ирсэн нь зөв шүү. Ер нь энэ аудитын дүгнэлтээр улсын үндсэн хөрөнгө, ТӨК-удын мөнгөөр хэрхэн, яаж тоглож болдог, хяналтгүйгээр яаж гарын салаагаар урсгаж болдгийг л бид нар харж байна шүү дээ. Энэ чинь хэдэн их наядаар яригдаад байгаа байхгүй юу. 500 гаруй албан тушаалтантай биш шүү дээ. Энэ чинь цаанаа улс төрийн намын томилгоонууд байгаа, улс төрийн намын хүчин зүйл, нөлөөллүүд байгаа. Тэгээд төгсгөлд нь дахиад хэлэхэд энэ гадаадын зээлээр хэрэгжээд байгаа 1.2 их наядын 112 төсөл ил болгочхоод бас над руу мэдээллийг нь албан бичгээр хүргүүлчхээч. Яг хаана, хаана, ямар, ямар аймагт 1.2 их наядын төсөл, хөтөлбөр хэрэгжээд байгаа юм бэ гэдэг. Энэ чинь эргээд та нар дээр буух, бид нар дээр буух, Их Хурал дээр буух, Засгийн газар дээр буух зовлон шүү дээ. Эргээд энэ чинь тэд хэзээ нэгэн цагт төлөх байхгүй юу. Тэгэхээр улсын төсөв заавал энэ чинь дарамт болж орж ирнэ. Тэгэхээр энэ дээр бас юмнуудаа ил болгоно шүү дээ.

Тэгээд бас Аудитын тухай хуулиар яадгийг нь би хараагүй болохоор мэдэхгүй байна. Энэ дүгнэлт ил болгочхооч. Иргэдийн мэдэх эрхийг бас хангамаар байна шүү дээ. Яг бодитоор. Иргэд энэ аудитын дүгнэлтийг уншаад яаж төрийн мөнгөөр тоглож болдгийг

бас хармаар байна шүү дээ. Тэд нар мэдэх эрхтэй шүү дээ. Манай өмнөх Их Хурал мэдэх эрхийг нь хаачихсан байхгүй юу. Тэгэхээр бас ийм саналтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа.
Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Бас Байнгын хороон дээр хэлсэн. Бас саяын манай гишүүдтэй нэлээн давхцаж байгаа учраас иргэдэд мэдэх эрхийг нь олгох үүднээс яах вэ ганц, хоёр зориуд тоо хэлье. Юуг нь ч асуух вэ. Нэгэнт төсвийн ерөнхийлөн захирагч нар нь өөрсдөө байхгүй, өмнөх парламент, өмнөх засаг гээд ингээд явж байгаа учраас. Тэгэхээр ёстой нөгөө төсвийн мөнгө уйлдаггүй гэдэг шиг л юм болдог юм байна. Тэгээд зүгээр ашиглалтгүй, хугацаа нь хэтэрсэн, угаасаа илүүдүүлж авсан бараа материалын мөнгөн дүн гэхэд л 73.8 тэрбум байна. Илүү, ерөөсөө шаардлагагүй бараа авчихсан. Эсвэл тэд нарынх нь хугацаа нь дуусчихсан. Энэ чинь асар их мөнгө шүү дээ. 73.8 тэрбум гэдэг чинь. 1.5 сая төгрөгийн цалинтай хүний жилийн орлого чинь л 18-хан сая төгрөг байна шүү дээ. 18 тэрбум гэдэг чинь хэдэн жил юм тээ?

Хоёрдугаарт, энэ урьдчилгаа дансны үлдэгдэл гэхээр асар их мөнгө байдаг юм байна. 5.1 их наяд төгрөг. Тэгээд үүний 82.2 хувь нь ТӨҮГ, ОНӨҮГ. Тэгэхээр энэ юуг хэлж байна гэвэл энэ ТӨҮГ, энэ ТӨК-уд дээр чинь асар их бэлэн мөнгө эргэлдэж байна. Асар их дүнтэй.

Тэгэхээр эндээс үүдээд аргагүй нөгөө “Эрдэнэс Тавантолгой”-н БЭТ-д цалин урамшуулал 1.2 тэрбум авсан байна гэдэг яриа явсан шүү дээ түүрүүчийн 7 хоногт. Энэ үнэн, худал нь мэдэхгүй. Гэхдээ аргагүй юм байна гэж бүүр бодогдлоо. Энэ их мөнгөн дүнтэй урьдчилгаа ингээд дансны үлдэгдэл ингээд ТӨК-удад байж байна гэдэг энэ бол асар их тоо байгаа юм.

Тэгээд одоо энд манайх чинь нөгөө авлигын индексээр байнга ухраад бараг

50-иад бүүр байраар ухарчихсан байгаа. Энэ дотор чинь зөвхөн авлига өгч, авсан тухай тийм асуудал яригддаггүй юм уу? Асар олон хүчин зүйлсийн нөлөөгөөр энэ индексийг гаргадаг. Энэ дээр нэг заалт юу байдаг вэ гэвэл гадаадын зээл, тусламжаар хийсэн тэр зүйлээ тайлагнадаггүй. Авахдаа хачин сайхан юм амлаад ерөөсөө зүгээр ингэнэ, тэгнэ, уулыг нурааж, усыг бараг яана гэдэг билээ тэрэн шиг ингээд авчихдаг мөртөө огт алга болдог.

Тэгээд энэний яг энэ нэг өгүүлбэр байна л даа. Гадаад зээл, буцалтгүй тусламжаар санхүүжсэн 10 төсөл, хөтөлбөрийг ингээд барьсан, байгууламж ингэсэн ийм тийм юмыг хөрөнгийн эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, төсвийн хаалтыг нь хийгээгүй, санхүүгийн тайланг бэлтгээгүй гээд яг тэр яригддаг асуудал энд орж ирж байна шүү дээ. Санхүүгийн тайлан бэлтгэж өгдөггүй юм байна. Гаднын мөнгөөр ингэж барилга, байшин барьдаг ч юм уу ямар ч төсөл хэрэгжүүлдэг юм мэдэхгүй. Ингэхээд тэгээд энэ бүх юмнууд чинь эргээд энэ бүх нөгөө Монгол Улсад тавьж байгаа тэр дүн дээр нөлөөлөөд байгаа юм. Бүх юм чинь харилцан уялдаатай байгаад байгаа юм гэж хэлмээр байна.

Тэгэхээр манай түрүүн маш зөв, зүйтэй юм ярьж байна л даа. Аудитын ерөнхий газар гэдэг энэ байгууллагын статусыг ч гэсэн ер нь яримаар юм байна. Яах ёстой юм тээ Үндсэн хуулийн байгууллага болгож байж сая та бүгдийн энэ гаргаж байгаа дүгнэлт, зөвлөмж нөгөө хэрэгжүүлэх ёстой байгууллагуудад хүрэх ёстой юм уу? Яах ёстой юм бас ойлгохгүй болж. Энэ хүн болгоны амнаас гарч байна шүү дээ. Хэчнээн хөөрхөн ингээд зөвлөмж юм өгөөд байдаг, хэрэгжилт нь эргээд тайлан байхгүй. Хэдэн хувь нь ямар арга хэмжээ авсан гэдгийг ер нь та нарт эргээд тайлагнадаг эсэхийг нь мэдэхгүй ингээд л ёстой баахан юм ингээд гаргаад л тавиад л тэгээд л өнгөрдөг. Энийг давтаж хэлмээргүй байна. Тэгэхээр энэ

дээр нэлээн тийм нэгдсэн бодлогын шинжтэй ёстой реформын шинжтэй ийм арга хэмжээ авч байж сая энэ та бүгдийн буюу аудитын газрын энэ их ажил үр дүнд хүрэх байх л гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд үг хэлж дууслаа. Би ганц, хоёр үг бас нэмээд хэлээдэхье гэж бодож байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны даргын хувьд, Төрийн байгуулалтын байнгын хороо энэ төрийн үйл ажиллагаа жигд, зөв зүйтэй явах хүрээнд хэд хэдэн хуулийн өөрчлөлт хийе гэсэн бодолтой байгаа. Гишүүд маань бас анхааралтай бас сонсоорой гэж бодож байна.

Нэгдүгээрт, Төрийн албаны тухай хуульд том өөрчлөлт хийе гэж бодож байгаа шүү.

Дээрээс нь энэ аудит. Аудитын асуудал маань Эдийн засгийн байнгын хороо хавьцаа байгаа байх, Төсөв дээр байж байгаа тийм Төсвийн байнгын хороон дээр байж байгаа. Тэгэхээр хэдүүлээ татаж аваад, цаашидаа та бүхний сая Баярмаа гишүүн ч бас хэллээ статус гэж. Энэ чинь Их Хурлын дэргэдэх асар том эрх бүхий байгууллага байхгүй юу даа. Эрх бүхий том байгууллага. Мэдэхгүй хуучин Төрийн нарийн бичгийн дарга байхдаа дүгнэлт нь яаж гарах болов уу гээд л ухаан алдчихдаг л байсан юм даа. Тэгээд та бүхний дүгнэлтээс ер нь айж байгаа амьтан байгаа юм уу цаана чинь? Бид нар ингэж хэлэлцээд байгаа болохоор.

Тэгэхээр би өчигдөр, уржигдар та бүхэнд үүрэг даалгавар өгсөн хуульдаа оруулах өөрчлөлтүүдээ. Би Наранчимэг аудитор би өөрт чинь туслах гээд байгаа юм шүү. Туслах гээд байгаа юм шүү. Танай байгууллагыг бэхжүүлэх, танай байгууллагыг хүчтэй байлгах, та бүхнээс төрийн төсвийн ерөнхийлөн захирагч нар айдаг байх, цаашаагаа хяналтаа сайн хийдэг байх, гүйцэтгэл нь сайн гардаг байхын тулд та бүхний хяналт маш чухал байж байж, та

бүхний хариуцлага өндөр байж байж ингээд явахын тулд та бүхэнд туслах гээд байгаа юм шүү Улсын Их Хурлын байгууллагын хувьд. Дэргэдэх байгууллагын хувьд.

Тийм болохоор тэр хуульдаа хэрвээ та бүхний гаргасан дүгнэлтийг хэрэгжүүлдэггүй юм бол тэрийг чинь Улсын Их Хурлууд татаж авчирч ярьдаг болъё эсвэл. Бид засгийн газраа байгуулсан шүү дээ. Засгийн газраа байгуулж чадсан юм бол Засгийн газар дотор байгаа тэр хариуцлагын асуудлуудыг бид нар татаж үздэг болъё л доо.

Хэрвээ та нар тогоон дотроо орчхоод байдаг юм бол та нарын асуудлыг бид нар буцааж татдаг болъё. Та нар тайлангаа бид нар тавьдаг болъё эсвэл. Тэгээд буцаад тэндээс нь хариуцлагагүй хандсан цаашаагаа дүгнэлтийнхээ хариуг эргээж тооцож авч чаддаггүй юм бол авдаг болгоё. Авдаг болчхоод авахгүй байвал бид нар та нартай хариуцлага тооцдог болъё. Тэгээд энэ хууль дээр өөрчлөлт оруулъя. Олон гишүүд дэмжээд ер нь ажлын хэсэгт бол ороод ажиллах юм байна гээд би итгэл үнэмшилтэй байгаа шүү. Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад олон намын тогтолцоо бий болох энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг миний хувьд бол хоёр гараа өргөөд дэмжсэн. Яг тэр хэмжээгээрээ өнөөдөр 5 нам энэ парламентад орж ирж байгаа. Орж ирээсэй гэж хүссэн. Сөрөг хүчний 4 нам байна. Одоо өнөөдөр энэ хүмүүсийг ингээд байгаа бүх байдлыг ингээд харахад бол үнэхээр өөрчлөлт хийх боломж, бололцоо нээгдэж байгаа байхгүй юу. Бид нар ингээд сууриар нь өөрчлөлт хийсэн шүү дээ. Үндсэн хуульд өөрчлөлт хийж байгаад. 126 гишүүнтэй, холимог тогтолцоо бүхий Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан. Энэний үр дүнг бид нар үзэх ёстой байхгүй юу.

Одоо микрофоныхоо араар нам яримааргүй байна Шижир гишүүн ээ 2, 3 дурдчихсан болохоор би хэлчээж байгаа

юм шүү уучлаарай. Цаашидаа зүгээр өөрчлөлтөө хэдүүлээ яримаар байна. Сөрөг хүчний 4-ийн 4 нам, эвсэл орж ирсэн. Одоо хэдүүлээ зүгээр эндээ нэгдээд өөрчлөлтүүдийг хийгээд хийгээд явах хэрэгтэй байна. Тэр утгаараа бол өнөөдөр та бүхэнд үүрэг даалгавар, ингээд дахиад давхар үүрэг даалгавар өгчхөж байгаа шүү. Төрийн албаны тухай хууль оруулж ирээрэй гээд би хэлчихсэн байгаа. Аудитын тухай хуульд хэдүүлээ эргээж харъя.

Засгийн газрын ерөнхийлөн захирагч нар одоо энэ дотор алга байна л гэж байна. Ирж суудаг болох хэрэгтэй байхгүй юу даа. Энийг зүгээр Бат-Эрдэнэ нэхээд байдаг биш энд сууж хариуцлагаа тооцуулдаг байх энэ системийг бид нар энэ цагаан дээр хараар нь бичиж өгөхөөс нааш бол ирэхгүй шүү дээ. Чангараад л эндээс чангараад л байвал ирдэг л байх. Чангарахгүй бол ирэхгүй зугтчихдаг, явчихдаг л байх. Ийм байж болохгүй байхгүй юу.

Тийм болохоор ирдэг бүх механизмыг нь энэ цагаан дээр нь хараар хийж өгч байж бид нар цааш цаашидаа бол хүнээр хэлүүлээд байдаггүйгээр өөрсдөө ирдэг, өөрсдөө тайлангаа тавьдаг, хариуцлага юмаа тооцдог, хариултаа өгдөг ийм л механизм бий болох ёстой байх.

Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газар 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан явуулж дууслаа.

Хэлэлцүүлгийг явуулсан талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Баярмаа гишүүн танилцуулах уу? Баярмаа гишүүн танилцуулъя. Төсвийн зарлагын

хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Дараагийн асуудалд оръё.

15.35 цаг

Хоёр дахь асуудал. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт ээлжит чуулганаар хэлэлцэх, ажлын хэсэгт баярлалаа. Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулна гэж 5.4 дэх хэсэгт гэж, 5.4 дэх хэсэгт Төрийн байгуулалтын байнгын хороо дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд хороо хууль санаачлагчийн саналыг нэгтгэн зөвлөлд танилцуулах бөгөөд Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл цаашид тогтоолын төсөл гэх төслийг боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар тогтоолын төслийг батална гэж, 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэгт Байнгын хороо боловсруулан Улсын Их Хуралд оруулах асуудлыг энэ хуулийн 45.2, 45.3, 45.4-д заасан журмын дагуу

хэлэлцэнэ гэж тус тус заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Тогтоолын төсөл маань хаана байгаа билээ? Тараачихсан байж байгаа тээ? Тогтоолын төсөлтэй холбогдуулан санал, асуулт асуух гишүүд байна уу? Асуулт, үг зэрэг явчих уу? Асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

“Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Хэлэлцлээ.

Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

14 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 57.1 хувиар тогтоол батлагдлаа.

Айн? Хэлэлцэх нь зүйтэй гэж. Хэлэлцэх нь зүйтэй гэж дүгнэгдлээ. Санал, дүгнэлтийг Баярмаа гишүүн унших уу дахиад чуулганд? Болормаа? Тэнд нэгмөсөн дахиад унших даа.

Одоо тогтоолын төслийг,
“Монгол Улсын Их Хурлын 2024 оны
намрын ээлжит чуулганаар хэлэлцэх
асуудлын тухай” Улсын Их Хурлын
тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал,
дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд
Улсын Их Хурлын гишүүн Баярмаа
гишүүн танилцуулна.

Өнөөдрийн хуралдаан
өндөрлөснийг мэдэгдье та бүхэнд.
Хуралдаан хаалаа.

15.40 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР